



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/160/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Албан шаардлага	15
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/19

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020553


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,914,424.69	125,198,386.61
33	АВЛАГА	49,900,000.00	21,264,798.43
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	79,827.43
335	Бусад авлага	49,900,000.00	21,184,971.00
3351	Байгууллагаас авах авлага	49,900,000.00	21,134,971.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	50,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	115,014,424.69	103,933,588.18
351	Түүхий эд материал	3,437,500.00	7,390,900.00
35110	Тусгай зориулалттай материал	2,891,000.00	6,844,400.00
35130	Эм боох материал	546,500.00	546,500.00
354	Хангамжийн материал	111,576,924.69	96,542,688.18
35410	Бичиг хэргийн материал	2,233,969.00	1,608,609.00
35420	Аж ахуйн материал	14,597,703.18	11,991,779.18
35430	Сэлбэг хэрэгсэл	63,000.00	63,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,113,052.51	965,800.00
35470	Бусад хангамжийн материал	93,569,200.00	81,913,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	323,769,675.68	366,126,294.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	323,769,675.68	366,126,294.15
392	Биет хөрөнгө	269,944,675.68	312,356,294.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	173,103,726.83	173,103,726.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,126,668.56	-20,355,252.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,965,000.00	34,965,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,372,583.27	-7,868,583.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	85,730,253.00	105,278,545.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,092,296.29	-58,097,013.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,186,781.45	101,963,854.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,478,673.12	-47,001,392.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,925,445.00	36,925,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,061,276.36	-7,723,002.72
39217	Ном	1,164,967.00	1,164,967.00
393	Биет бус хөрөнгө	53,825,000.00	53,770,000.04
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-625,000.00	-679,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	53,550,000.00	53,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	488,684,100.37	491,324,680.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,107.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,107.00	00.00
413	Өглөг	30,107.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,107.00	00.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	488,653,993.37	491,324,680.76
51	Засгийн газрын хувь оролцоо	488,653,993.37	491,324,680.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		94,718,933.00	94,718,933.00
51101	Өмч: - төрийн	94,718,933.00	94,718,933.00
512	Хуримтлагдсан үр дүн	227,024,563.86	230,049,661.25
51210	Өмнөх үеийн үр дүн	227,024,563.86	227,378,973.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,670,687.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,910,496.51	166,556,086.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	488,684,100.37	491,324,680.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	852,501,515.00	626,525,694.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,545,300.00	41,805,951.00
120	Нийтлэг татварын бус орлого	52,545,300.00	41,805,951.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,545,300.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,300.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,538,000.00	00.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	4,138,551.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	00.00	37,667,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,450,215.00	122,916,043.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	634,506,000.00	461,803,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	151,406,915.00	108,350,571.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,733,343.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	21,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,673,572.00	86,850,571.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,043,300.00	14,565,472.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,043,300.00	14,565,472.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	706,481,576.86	623,855,006.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,481,576.86	623,855,006.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,477,062.94	596,890,668.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,316,697.16	128,305,285.00
210101	Үндсэн цалин	131,316,697.16	108,704,252.00
210102	Нэмэгдэл	00.00	19,601,033.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,102,278.92	21,682,518.83
210201	Тэтгэврийн даатгал	15,355,374.05	16,535,152.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,819,879.92	1,312,042.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,270,209.38	1,022,752.89
210204	Ажилгүйдлийн даатгал	332,435.81	255,687.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,324,379.75	2,556,883.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,325,011.00	13,579,972.00
210301	Гэрэл, цахилгаан	1,209,531.00	1,993,318.00
210302	Түлш, халаалт	10,729,920.00	10,586,854.00
210303	Цэвэр, бохир ус	385,560.00	999,800.00

**Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	6,529,247.30	14,168,446.51
210401	Бичиг хэрэг	3,626,260.00	2,662,860.00
210402	Тээвэр, шатахуун	1,172,880.30	10,683,793.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,107.00	651,793.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	170,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	985,500.00
210604	Урсгал засвар	00.00	985,500.00
2107	Томилолт, зочны зардал	267,000.00	488,600.00
210702	Дотоод албан томилолт	267,000.00	488,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	479,306,631.19	855,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	478,706,831.19	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	216,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	91,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	238,000.00	280,500.00
210807	Газрын төлбөр	62,000.00	155,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,630,197.37	416,824,446.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	372,402,165.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,915,000.00	2,371,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,715,197.37	42,050,481.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,004,513.92	26,964,337.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	21,124,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	21,124,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,943,042.92	5,839,537.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,943,042.92	5,839,537.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,061,471.00	00.00
213404	Хөрөнгийн	18,061,471.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,019,938.15	2,670,687.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,980,760.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,980,760.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,980,760.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	143,039,178.15	2,670,687.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31		/төгрөг/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	799,963,515.00	584,719,743.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,300.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,300.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,300.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,300.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	799,956,215.00	584,719,743.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	634,506,000.00	461,803,700.00

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	151,406,915.00	108,350,571.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,733,343.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	21,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,673,572.00	86,850,571.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,043,300.00	14,565,472.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,043,300.00	14,565,472.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	791,530,715.00	584,719,743.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	791,530,715.00	584,719,743.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,936,271.08	536,620,434.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,572,847.00	127,859,698.00
210101	Үндсэн цалин	105,297,406.00	108,258,665.00
210102	Нэмэгдэл	27,275,441.00	19,601,033.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,099,066.08	17,138,864.26
210201	Тэтгэврийн даатгал	10,836,292.04	11,999,897.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,315,695.01	1,303,642.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,052,555.81	1,022,752.89
210204	Ажилгүйдлийн даатгал	263,135.20	255,687.52
210205	Эрүүл мэндийн даатгал	2,631,388.02	2,556,883.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,325,011.00	13,579,972.00
210301	Гэрэл, цахилгаан	1,209,531.00	1,993,318.00
210302	Түлш, халаалт	10,729,920.00	10,586,854.00
210303	Цэвэр, бохир ус	385,560.00	999,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,107,300.00	3,477,200.00
210401	Бичиг хэрэг	2,507,300.00	1,683,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	1,192,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	431,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	170,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	985,500.00
210604	Урсгал засвар	00.00	985,500.00
2107	Томилот, зочны зардал	558,500.00	488,600.00
210702	Дотоод албан томилот	558,500.00	488,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,983,547.00	23,527,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	597,423,747.00	22,672,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	216,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	91,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,000.00	280,500.00
210807	Газрын төлбөр	50,000.00	155,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290,000.00	349,562,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	347,190,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,290,000.00	2,371,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,594,443.92	48,099,308.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	589,930.00	21,124,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	21,124,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	589,930.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,943,042.92	5,839,537.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,943,042.92	5,839,537.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,061,471.00	00.00
213404	Хөрөнгийн	18,061,471.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	21,134,971.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	21,134,971.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,432,800.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,432,800.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,432,800.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,432,800.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,432,800.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,432,800.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	110,254,385.72	371,883,815.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	110,254,385.72	371,883,815.23
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	143,039,178.15	143,039,178.15
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,024,563.86	488,653,993.37
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,024,563.86	488,653,993.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	354,410.00	354,410.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,378,973.86	489,008,403.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-354,410.00	00.00	-354,410.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,670,687.39	2,670,687.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,556,086.51	230,049,661.25	491,324,680.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,547,700.00	470,529,634.26	6,018,065.7	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,547,700.00	470,529,634.26	6,018,065.7	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,422,900.00	449,404,834.26	6,018,065.7	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,708,100.00	127,859,698.00	4,848,402.0	96.3
210101	Үндсэн цалин	107,417,200.00	108,258,665.00	-841,465.0	100.8
210102	Нэмэгдэл	25,290,900.00	19,601,033.00	5,689,867.0	77.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,915,700.00	17,138,864.26	776,835.7	95.7
210201	Тэтгэврийн даатгал	12,607,300.00	11,999,897.45	607,402.6	95.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,327,100.00	1,303,642.80	23,457.2	98.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,061,700.00	1,022,752.89	38,947.1	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	265,400.00	255,687.52	9,712.5	96.3
210205	Эрүүл мэндийн даатгал	2,654,200.00	2,556,883.60	97,316.4	96.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,744,000.00	13,579,972.00	164,028.0	98.8
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,993,318.00	6,682.0	99.7
210302	Түлш, халаалт	10,742,000.00	10,586,854.00	155,146.0	98.6
210303	Цэвэр, бохир ус	1,002,000.00	999,800.00	2,200.0	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	3,477,200.00	3,477,200.00	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	1,683,000.00	1,683,000.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,192,300.00	1,192,300.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	431,900.00	431,900.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	170,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	985,500.00	14,500.0	98.6
210604	Урсгал засвар	1,000,000.00	985,500.00	14,500.0	98.6
2107	Томилолт, зочны зардал	488,600.00	488,600.00	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	488,600.00	488,600.00	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	901,700.00	855,900.00	45,800.0	94.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,600.00	216,600.00	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	119,300.00	79,500.00	39,800.0	66.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,300.00	91,300.00	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,000.00	33,000.00	6,000.0	84.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	280,500.00	0.0	100.0
210807	Газрын төлбөр	155,000.00	155,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,187,600.00	285,019,100.00	168,500.0	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	282,647,300.00	282,647,300.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,540,300.00	2,371,800.00	168,500.0	93.4

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,124,800.00	21,124,800.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,124,800.00	21,124,800.00	0.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,124,800.00	21,124,800.00	0.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,547,700.00	470,529,634.26	6,018,065.7	98.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	461,803,700.00	455,964,162.26	5,839,537.7	98.7
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	461,803,700.00	455,964,162.26	5,839,537.7	98.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,744,000.00	14,565,472.00	178,528.0	98.8
132001	Орон нутгийн төсвөөс	14,744,000.00	14,565,472.00	178,528.0	98.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00		
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31		/төгрөг/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,406,915.00	108,350,571.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,406,915.00	108,350,571.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,345,444.00	87,215,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,345,444.00	22,672,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,345,444.00	22,672,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	64,543,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	64,543,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,061,471.00	21,134,971.00
2134	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,061,471.00	21,134,971.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	18,061,471.00	21,134,971.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	151,406,915.00	108,350,571.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	151,406,915.00	108,350,571.00
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,516,843.00	21,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	132,890,072.00	86,850,571.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг дарга Н.Мэндбаяр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Батнасан нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжих таатай орчин бий болгоход оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 706,481.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,597.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,418.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,550.5 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,640.6 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,914.4	125,198.4	(39,716.0)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	49,900.0	21,264.8	(28,635.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	115,014.4	103,933.6	(11,080.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	323,769.7	366,126.3	42,356.6
Үндсэн хөрөнгө	462,526.2	507,851.5	45,325.4
Хуримтлагдсан элэгдэл	(138,756.5)	(141,725.2)	(2,968.7)
Нийт хөрөнгө	488,684.1	491,324.7	2,640.6
Өр төлбөр	30.1	-	(30.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	488,654.0	491,324.7	2,670.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	488,684.1	491,324.7	2,640.6

Авлагын дансны үлдэгдэл 28,635.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд авлагаар тусгасан 49,990.0 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн бөгөөд тайлант онд 1 ажилтны тэтгэмжийн зардал болох 21,124.8 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 103,933.6 мянган төгрөг болж 11,080.8 мянган төгрөгөөр буурсан нь түүхий эд материалын дансны үлдэгдэл 3,953.4 мянган төгрөгөөр өсөж, бичиг хэргийн материал 625.3 мянга аж ахуйн материал 2,605.9 мянга, бусад хангамжийн материал 11,655.7 мянган төгрөгөөр буурсан ба урсгал төсвийн худалдан авалтаар 39,256.7 мянган төгрөгийн эд материал худалдан авсан бөгөөд 50,849.3 мянган төгрөгийг бараа материалыг зарцуулж, 3,626.8 мянган төгрөгийн материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн №137 дугаар тогтоолоор акталсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 507,851.5 мянган төгрөг болж 45,356.6 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлагаар бүртгэлтэй 48,719.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, бусад байгууллагаас 1,980.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирсэн 35,687.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн №137 “Хөрөнгө данснаас хасах тухай” тогтоолоор 39,081.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу данснаас хассан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 488,654.0 мянган төгрөг болж 2,670.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,670.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 880,195.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 856,949.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 386,967.1 мянган төгрөгөөр бууруулж 493,228.2 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд үүнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 30,206.3 төгрөг буюу 16,697.2 мянган төгрөгөөр, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 132,708.1 мянга буюу 111,907.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 283,327.1 мянга буюу 217,447.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь хүүхэд хамгааллын зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 476,547.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 461,803.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 14,744.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 455,964.2 мянга, орон нутгийн төсвөөс 14,565.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 470,529.6 мянган төгрөгийг зарцуулж, 5,839.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 470,529.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 4,848.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 776.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 164.0 мянга,

бараа үйлчилгээний бусад зардлыг 168.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 21,500.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 86,850.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан бөгөөд 21.134.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар “Хамтдаа шийдье” хамтарсан багийн сургалтын санхүүжилт 17,581.8 мянга, чип баг сайн дурын ажилтан бэлтгэх зардал 4,022.0 мянга, хамтарсан багийн сургалтын зардал 17,360.5 мянган төгрөгийн санхүүжилт НҮБ-ийн хүүхдийн сангаас, тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмж 21,124.8 мянга, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн дэмжлэг болох 8,700.0 мянган төгрөг, өмнөх оны төвлөрүүлэлт 18,061.5 мянган төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд, зарцуулсан байна. Тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмж болох 21,124.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

Тус байгууллага нь хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр хүүхдийн тусламжийн утсанд эрхийн зөрчилтэй холбоотой 146 дуудлага, мэдээллийн хүлээн авч, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн хүчирхийллээс сэргийлэх зорилгоор "Нэгдүгээрт хүүхэд" үндэсний аян, "Хүүхдийн хөдөлмөрийг устгая" үндэсний аян, "Өрөх бүр үйлдвэрлэгч иргэн бүр ногоочин", "Эх оронч залуу" үндэсний аян, "Ёс зүй хандлага төвтэй төрийн алба" аяныг зохион байгуулж, “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 623,855.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 82,626.6 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар буурсан байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулдаг НҮБ-ийн хүүхдийн сангийн хамтарсан багийн төсөл нь тус байгууллагад 2017 оноос хойш хэрэгжиж байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нэмэгдсэн байгаа бол, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 867,304.6 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийг 3 дугаар улирал, 6.1.5-д заасан аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, 6.4.5-д заасан орлого, зарлагын 72,728.2 мянган төгрөгийн 6 гүйлгээг тус тус хугацаа хоцроож, 6.4.5-д заасан орлого, зарлагын 117,386.9 мянган төгрөгийн 10 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 493,228.2 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 16,680.5 мянган төгрөг хасаж баталснаас 461,803.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 14,744.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 30,206.3 мянган төгрөгөөр, тодотголоор 13,744.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 13,579.9 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 16,462.3 мянган төгрөг буюу 54.5 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 1683.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1683.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь дээрх тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 51,754.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 51,754.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд НҮБ-ийн хүүхдийн сангийн санхүүжилтийн зарцуулалтыг авч үзэх боломжгүй байсан тул дараагийн аудитаар авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23,182.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 23,182.3 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийг 3 дугаар улирал, 6.1.5-д заасан аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, 6.4.5-д заасан орлого, зарлагын 72,728.2 мянган төгрөгийн 6 гүйлгээг тус тус хугацаа хоцроож, 6.4.5-д заасан орлого, зарлагын 117,386.9 мянган төгрөгийн 10 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.5 “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан орлого, зарлагын 117,386.9 мянган төгрөгийн 10 гүйлгээг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

4.2 Зөвлөмж

1. Ажил олгогчоос төлөх 461.2 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас төлсөн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" -тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" -ыг бүрэн мөрдөж, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2. Тайлант хугацааны зардлын гүйлгээг анхан шатны баримттай тулгахад цахилгааны зардлаас 930.0 мянган төгрөгийн цахилгааны утас, цэвэр бохир усны зардлаас 330.0 мянган төгрөгийг цэвэр усны шугамын засварын зардалд зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" -ыг бүрэн мөрдөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 493,228.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны 10 дугаар сард 16,680.5 мянга буюу 3.5 хувиар бууруулан 476,547.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэсэн ч, бичиг хэргийн зардлыг бууруулаагүй, мөн иргэний иргэний өргөх ёслолын үйл ажиллагаа болон сургалт зохион байгуулсан, томилолтын зардалд хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.5 "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.6 "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" 1.9 "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, бичиг хэрэг болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

4. Тайлант оны нэмэлт санхүүжилтийн дансыг тулгахад тэтгэвэр тогтоолгосон ажилтны тэтгэмж болох 21,124.8 мянган төгрөг тус байгууллагын дансанд орсон ч уг ажилтны хүүхэд 6 нас хүрээгүй гэсэн шалтгаанаар тэтгэмж олгогдоогүй буцаан төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Даатгуулагч нь нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-оос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Цаашид тухайн оны төсвийн төслийг боловсруулахдаа ажилтнуудын өндөр насны тэтгэмжийг хууль журмыг мөрдлөг болгон үнэн зөв, үндэслэлтэй төлөвлөж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	5	23,182.3					1	0	4	23,182.3

_____оОо_____